



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 11 сарын 21 өдөр

Дугаар А/94

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлан, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг танилцуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, ажиллах удирдамжийг 2 дугаар хавсралтаар, төсвийн зардлыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Албан томилолтын тайланг ажлын 3 өдөрт багтаан танилцуулахыг ажлын хэсэгт даалгасугай.

3.Ажлын хэсэгт ажиллах албан хаагчдын томилолтын зардлыг зохих журмын дагуу тооцож, дотоод томилолтын зардлаас гаргахыг Ерөнхий нягтлан бодогч (Д.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ



132013735

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 21 -ны өдрийн
1199 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн
ахлагч:

Н.Ганболд

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн дарга

Гишүүд:

Д.Нарангэрэл

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн дарга

В.Дарханбаатар

Төрийн өмчийн удирдлага,
зохицуулалтын хэлтсийн Удирдлага,
төлөөллийн албаны дарга


Р.Ширчинням

Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын
хэлтсийн мэргэжилтэн

Б.Базаррагчаа

Жолооч

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны .11 дугаар сарын .11-ны өдрийн
21/194 дугаар тушаалын 2 дугаар хавсралт



УДИРДАМЖ

Нэг. Ерөнхий мэдээлэл

Албан томилолтын ажлын зорилго, чиглэл:


Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлан, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг танилцуулах.

Албан томилолтоор ажиллах газар:

Өвөрхангай аймаг

-----oOo-----

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 11 дугаар сарын 23-ны өдрийн
11/24 дугаар тушаалын 3 дугаар хавсралт



ОРОН НУТАГТ ТОМИЛОЛТООР АЖИЛЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Өвөрхангай аймгийн Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааг шалган зааварчлан, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлын хэсгийн тайлан дүгнэлтийг танилцуулах ажлаар Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Н.Ганболд, Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтсийн дарга Д.Нарангэрэл, мэргэжилтэн Р.Ширчинням, Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга В.Дарханбаатар, жолооч Х.Базаррагчаа нарын албан томилолтын зардлын төсөв.

Хугацаа: 2023 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс 11 дүгээр сарын 24-ний өдрүүдэд /хуанлийн 2 хоногоор/ хийж гүйцэтгэнэ.

Д/д	Зардлын төрөл	Төсөвлөсөн /төгрөгөөр/
1	Байр: 5 хүн х 2 хоног х 90,000 =900,000.00 Хоол: 5 хүн х 2 хоног х 28,000 =280,000.00	1,180,000.00
Нийт дүн:		1,180,000.00

Тайлбар: Дотоод томилолтын зардлыг тооцохдоо Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар тушаалаар баталсан “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай” тушаалыг үндэслэв.

----- о 0 о-----